

ЯПОНЫ “ХӨӨЖ ГҮЙЦЭХ, ГҮЙЦЭЖ ТҮРҮҮЛЭХ” ЭДИЙН ЗАСГИЙН ФИЛОСОФИ БА МОНГОЛ УЛС: СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.УЛАМБАЯР

ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын
сургуулийн захирал, доктор, профессор

Түлхүүр үгс: Японы технологи, эдийн засаг, философи, хөөж
гүйцэх, гүйцэж түрүүлэх, өрсөлдөх чадвар, галуун цуваа

I. Удиртгал

Хүчний тэнцвэрт суурилсан олон улсын харилцааны реалист онолын гол төлөөлөгч АНУ-ын нэрт геополитикч, профессор Ханс Иоахим Моргентау 1948 онд анхны хэвлэл нь гарч, эдүгээ өрнө дахинд их сургуулиудын олон улсын харилцааны онолын гол сурах бичиг болсон *Politics Among Nations: The Struggle for Power and Peace* хэмээх нэн дорвилог бүтээлдээ тэрбээр дипломат ажиллагааны үндсэн дөрвөн зорилтыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. “Дипломат бодлого өөрийн хүч чадавх, боломж, бололцоогоо зөв үнэлж, тодорхойлсон байх ёстой,
2. Дипломат бодлого нөгөө улсынхаа зорилгыг зөв үнэлж, томьёолох ёстой,
3. Дипломат бодлого хоёр улсын зорилго хоорондоо хэр уялдаж байгааг зөв үнэлж тодруулах ёстой,
4. Дипломат бодлого дээрхэд тулгуурлан өөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга замыг зөв сонгох ёстой”¹ гэж үзжээ.


Гадаад бодлого, дипломат ажиллагаанд өөрийгөө болон харилцагч улс орноо үнэн зөв тодорхойлох нь амжилт олохын чухал нөхцөл юм.

Энэ бол гадаад бодлогын онол, үзэл баримтлалыг боловсруулахад судалгааны чухал аргачлал мөн.

Мэйжигийн хувьсгалын дараахан 1871 онд Гадаад хэргийн сайд Ивакура Томомигийн (Iwakura Tomomi) ахалсан төлөөлөгчдийн Америк, Европын гүрнүүдэд хийсэн 18 сарын танилцах аялал нэн чухал ач

¹ Morgenthau Hans J. *Politics Among Nations: The Struggle for Power and Peace. N.Y., Seventh edition. 2006, pp. 539-540*

Диаграм 1. Ханс Моргентауны дипломатын 4 зорилт



холбогдолтой.² Төлөөлөгчдийн аяллын зорилго нь тэгш бус гэрээг өөрчлөх талаар яриа хэлэлцээг эхлүүлэх, өрнөдийн гүрнүүдийн хөгжилтэй танилцах явдал байжээ. Төлөөлөгчид өрнө дахинд нэг жил зургаан сар аялж, их гүрнүүдийн орчин үеийн хөгжил цэцэглэлттэй биечлэн танилцаж нутагтаа эргэн ирээд Засгийн газартаа өргөн барьсан тайлан нь хожмын Японы хөгжил дэвшил, гадаад бодлогод нь ихээхэн нөлөө үзүүлсэн байна.

Төлөөлөгчдийн гишүүн, Ивакүра Томомигийн хувийн нарийн бичгийн дарга, түүхч Күмэ Күнитакэгийн бичсэн “АНУ, Европоор аялсан Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын ажиглалтын үнэн тэмдэглэл”³ (*Tokumei Zenken Taishi Bei-O Kairan Jikki*) хэмээх тэмдэглэл хэвлэгдэн гарсан нь нүдээр хийсэн нарийн ажиглалт, байдлыг бодитойгоор харж үнэлж бичсэнээрээ ихээхэн ач холбогдолтой байв. Тэд Азийг Европтой харьцуулан, Азийг хоцрогдсон, гэхдээ баялаг ихтэй гэж үзсэн юм.

Өөрийгөө болон дэлхий дахиныг зөв үнэлэх гэдэг энэ ажгуу.

Гэтэл өрнө дахины хөгжилт цэцэглэлт, хүч чадлын талаар ямар ч ойлголт, мэдээлэл байхгүй, өөрийгөө зөв үнэлэх чадамжгүй Манж Чин гүрний Сайшаалт Ерөөлт хаанаас Их Британийн III Жорж хаанд илгээсэн захидал дээрхээс тэс өмнөө баримт юм.

² Nish, Ian. (1998) *The Iwakura Mission to America and Europe: A New Assessment*. Richmond, Surrey: Japan Library. ISBN 9781873410844; ISBN 0415471796; OCLC 40410662

Saburō, Izumi (7 June 2019). “The Iwakura Mission: Japan’s 1871 Voyage to Discover the Western World”. *nippon.com*. Retrieved 18 June 2021.

Ruxton, Ian (1998). Nish, Ian (ed.). *The Iwakura Mission to America and Europe: A New Assessment*. Japan Library (Curzon Press). p. 35. ISBN 0-203-98563-X.

Checkland, Olive (1998). *The Iwakura Mission, industries and exports* (PDF) (Discussion Paper ed.). London: The Suntory Center. p. 28.

³ 「特命全権大使米欧回覧実記」 Kume Kunitake. Healey, Graham and Tsuzuki Chushichi, eds. *The Iwakura Embassy, 1871-73 : A True Account of the Ambassador Extraordinary & Plenipotentiary's Journey of Observation Through the United States of America and Europe*. (The Japan Documents, 2002)

Зураг 1. Ивакура Томомийн тэргүүлсэн аяллын төлөөлөгчид




Гадаад хэргийн сайд Iwakura Tomomi (1825-1885)



Түүхч Kune Kunitake (1839-1931)



Аяллын тэргүүлэгч гишүүд, Сан Франциско хотод. Зүүнээс Кидо Такайоши, Ямагучи Масука, Ивакура Томоми, Ито Хиробуми, Окубо Тошимичи нар. 1872 оны 1 дүгээр сар



АНУ, Европ дахь Ивакурагийн аяллын төлөөлөгчид Америкийн эрэгт хүрэлцэн ирж буй нь. Мэйжигийн дурсгалын зургийн галерей.

Чин гүрний хаан бичихдээ: “Тэнгэрийн тааллыг соёрхогч эзэн хаан миний удирдамжийг анхааралдаа авахыг Английн хаанд зааварлаж байна: Дөрвөн далайн хоорондох газар нутгийг эзэгнэгч Тэнгэрийн хаант улс нь ...ховор бөгөөд үнэт эд зүйлсийг цэгнэж үздэггүй...түүнтэй нэгэн адил танай үйлдвэрийн бараа бидэнд өчүүхэн ч хэрэг байхгүй... Тиймийн учир бид...таны харьяат элч нарыг амар мэнд нутагтаа буцахыг тушаасан. Хаантан та бол үүрд хүлцэнгүй байхаа тангараглаж, улам бат үнэнч явж, ердөө бидний хүсэл таашаалын дагуу хөдөлж байх ёстой”⁴ гэсэн байдаг.

“Британийн буун дуу цуурайтсанаар Манж Чин улсын сүр хүчин эргэлт буцалтгүй унаж, Тэнгэрийн эзэнт улс мөнх хэмээх сүсэг бишрэл эгнэгт замхран арилав”⁵ гэж К.Марксын бичсэн нь үнэн юм. Тэрбээр “Гар хөдөлмөрт түшиглэсэн Хятадын үйлдвэр нь машинтай өрсөлдөж чадахгүй болов. Ялагдашгүй Тэнгэрийн эзэнт улс нийгмийн хямралд оров. Алба гувчуур залгахаа байж, улс орон дампууралд унаж, хүн ам үй олноор хоосорч, бослого үймээн гаргах, эзэн хааны түшмэдийг, буддын шашны лам нарыг олноор алах талах явдал эхэлжээ. Тус орон мөхөхөд хүрч, хүчирхийлэх хувьсгалын аюул тулгарав”⁶ гэж цааш нь үргэлжлүүлэн бичсэн билээ. Энэ бол өөрийгөө үнэн зөв үнэлж чадаагүйн тодорхой жишээ юм.

⁴ Zb.Brzezinski. The Grand Chessboard: American Primacy and Its Geostrategic Imperatives. BasicBooks.: 1997, pp.14-15

⁵ Karl Marx. Trade or Opium? *New York Daily Tribune*. Articles on China, 1853-1860, September 20, 1858

⁶ *Ibid*,

II. Японы эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал: мөн чанар, үзэгдэл

Япон улс Мейжи эрин үеэс орчин үежих үйл явцыг шийдэмгий эхлүүлж, Манж Чин, Хаант Орос хөрш хоёр гүрэнтэйгээ дайтан нэгэнт ялж, улмаар XX зууны эхнээс Азийн цорын ганц *de facto* их гүрний статустай улс болж, Солонгосын хойгийг өөртөө хавсарган нэгтгэснээр Азийн эх газрын гүрэн болон гарч ирсэн нь Зүүн хойд Азийн олон улсын харилцааны хүчний тэнцвэрт томоохон өөрчлөлтийг оруулсан юм. Хүч чадлаа улам бүр мэдрэх болсон Япон гүрэн өөрийн геополитикийг “Азийнхан Азидаа” (Asia for the Asiatics) хэмээн томъёолж, “Аугаа Их Дорнод Азийн Хамтын Цэцэглэлтийн Хүрээ” (大東亜共栄圏 Greater East Asia Co-Prosperity Sphere)-г тодорхойлж, энэхүү бүс нутагт шинэ дэг журмыг илбэн тохинуулах үүргийг соёлжсон Их Наран улс гүйцэлдүүлэх ёстой гэж үзэж байсан юм. Энэ нь Дорнод Азийн хэрэг явдалд Өрнөдийн гүрнүүд хошуу, гараа дүрэх ёсгүй гэж үзэж байсанд оршиж байжээ.

Япон дэлхийн II дайны Алс Дорнод, Номхон далайн талбарт ялагдсан боловч түүнээс хойших бүх цаг үеийн хамгийн чухал эдийн засгийн хөгжлийн хосгүй гайхамшигийг түүхэнд анх удаа харуулав.

1955 оноос 1970-аад оны эхэнд Японы эдийн засгийн бодит өсөлт дунджаар бараг 10 хувьд хүрсэн нь АНУ-д 3.4, ХБНГУ-д 5.4, Францад 5.6, Их Британид 3.0, Италид 5.6 хувь тус тус байснаас хоёр дахин өндөр байжээ.⁷ Японы аж үйлдвэрлэл 1951 он гэхэд дайны өмнөх түвшинд нэгэнт хүрсэн байв.⁸ Япон нь 1949-1952 онд АНУ-ын дайны дараах Европын сэргээн босгох мега хөтөлбөр Маршаллын төлөвлөгөөнд албан ёсоор хамрагдаагүй нь тус улсын эдийн засаг сэргэх замдаа нэгэнт орсныг харуулсан бөгөөд харин АНУ-ын тусгай сангийн шугамаар 2.1 тэрбум долларын тусламж авч, үр дүнтэй ашиглажээ.⁹

АНУ-ын дэмжлэгээр 1952 оны 8 дугаар сарын 13-нд *Bretton Woods*-ийн институт болох ОУВС, Шинэчлэл, хөгжлийн олон улсын банк буюу өнөөгийн Дэлхийн банк, 1955 онд ГАТТ-д, 1956 оны 10 дугаар сарын 19-нд ЗХУ-тай харилцаагаа хэвийн болгосны¹⁰ дараа мөн оны 12 дугаар

⁷ Johnson, Chalmers (1982). *MITI and the Japanese Miracle: The Growth of Industrial Policy, 1925–1975*. Stanford University Press. p. 211. ISBN 9780804712064.


⁸ Ichiro, Nakayama (1964). *Industrialization of Japan*. Tokyo.: p. 7
“The Sources of Japanese Economic Growth: 1955-71” Micko Nishimizu and Charles R. Hulten. Journal of “The Review of Economics and Statistics” Vol. 60, No. 3 (Aug., 1978), pp. 351-361 (11 pages) Published By: The MIT Press <https://doi.org/10.2307/1924160> <https://www.jstor.org/stable/1924160>

⁹ Michael Beckley; Yusaku Horiuchi; Jennifer M. Miller (2018). “America's Role in the Making of Japan's Economic Miracle”. *Journal of East Asian Studies*. 18 (1): 1–21. doi:10.1017/jea.2017.24.

¹⁰ Soviet-Japanese Joint Declaration. October 19 1956, Moscow, USSR

сарын 18-нд НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элсэж, 1964 оны 4 дүгээр сарын 18-нд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага-OECD-д нэгджээ.¹¹

Диаграм 1. Хөөж гүйцэх, гүйцэж түрүүлэх үзэл баримтлалын үе шат



Дээр дурдсан бүх бодлогын арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд 1949 онд байгуулагдсан Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам, Эдийн засгийн тогтворжуулалтын Хороо *think tank*-ийн үүрэг гүйцэтгэжээ. Худалдаа, үйлдвэрийн яамны шийдвэрээр 1951 онд Японы Хөгжлийн банкийг байгуулснаар хувийн секторт бага хүүтэй урт хугацааны зээлийн бодлогыг хэрэгжүүлэв. Тус яам 1954 онд мэдэгдэхдээ: 1949-1953 оны хооронд үр ашиг бүхий эдийн засгийн иж бүрэн тогтолцооны үндсийг нэгэнт тавьсан гэжээ¹². Америкийн эдийн засагч Чолмерс Жонсон 1982 онд Стэнфордын их сургуульд хэвлүүлсэн “Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам ба Японы гайхамшиг: Аж үйлдвэрлэлийн бодлогын өсөлт 1925-1975” бүтээлдээ: Хүнд үйлдвэржүүлэх бодлогын дүнд “Японы эдийн засгийн гайхамшигийг бүтээгч гол архитектурч нь Ерөнхий сайд Хаяато Икеда байсан”¹³ гэжээ. Тэрбээр 10 жилд орлогыг 2 дахин нэмэгдүүлэх зорилт тавьсан юм. 1960-аад оны арван жилийг “*Golden sixties*” буюу “Алтан жаран” хэмээн нэрлэдэг агаад 1965 онд ДНБ 91 тэрбум ам.долларт хүрсэн бол 1980 онд гэхэд 1.06 их наяд ам.доллараар хэмжигдэж, даруй 10.5 дахин өсөв. Хаяато Икедагийн Засгийн газрын “орлогыг хоёр дахин өсгөх төлөвлөгөө” нь бага хүүтэй зээл, уян хатан татварын бодлого, суурь байгууламж буюу дэд бүтцийн салбар болох хурдны авто зам, өндөр

¹¹ Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. ХХ зууны сүүлийн хагаст. Дэд боть. УБ., 2020, 250-264 дэх тал

¹² Johnson, Chalmers (1982). *MITI and the Japanese Miracle: The Growth of Industrial Policy, 1925–1975*. Stanford University Press. pp. 118-125. ISBN 9780804712064

¹³ Johnson, Chalmers (1982). *MITI and the Japanese Miracle: The Growth of Industrial Policy, 1925–1975*. Stanford University Press. pp. 118-125.

хурдны төмөр зам болон метро, нисэх онгоцны буудал, далайн боомтын техникжилт хийгээд далан, харилцаа холбооны салбар дахь өргөн хүрээтэй хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлснээр менежсэн эдийн засгийг буй болгожээ.



1960-1964 онд Ерөнхий сайдаад ажилласан Хаяато Икеда

Дайнд сүйдсэн, түүхий эд, байгалийн баялаг хомс Японы эдийн засаг богино хугацаанд гайхамшгийг үзүүлсэн гол нууц нь *нэгд*, үр ашиг бүхий урт, дунд хугацааны стратегийн төлөвлөлт, эдийн засаг дахь төрийн уян хатан зохицуулалт, хувийн болон улсын сектор, хувь хүмүүст үйл ажиллагаагаа тууштай явуулах тааламжтай эрх зүйн орчныг бүрдүүлсэн, хоёрт, аж үйлдвэрийн салбарт зохистой бүтцийн өөрчлөлт хийж, бүх салбарыг биш, харин стратегийн тэргүүлэх болд, ган, металлурги, нефть, химийн үйлдвэр, авто болон суурь машин, электроник, жижиг-дунд үйлдвэрлэлийг тэргүүн зэрэгт хөгжүүлсэн, *гуравт*, дайнд ялагдсан гол сургамж нь технологийн хоцрогдол байсанд дүн шинжилгээ хийж, шинжлэх ухаан-технологийн дэвшлийг үйлдвэрлэлд хурдан шуурхай нэвтрүүлсэн, *дөрөвт*, үйлдвэрлэлийн үр ашигтай удирдлагын менежментийн тогтолцоог буй болгосон, *тавд*, маркетинг, зах зээлийн судалгаанд тулгуурласан экспортын чиглэлтэй гадаад худалдааны цогц бодлого явуулсан, *"...худалдаа бол олборлолтын үйл ажиллагаа, худалдаа бол үйлдвэрлэл гэж үзсэн бөгөөд "гадаад худалдаа нь зээл, тусламжаас хавьгүй дээр" гэсэн зарчмыг удирдлага болгосон, зургаад*, банк, санхүүгийн зохистой мөнгө-зээлийн бодлого, *долоод*, зах зээлийн механизмын үйлчлэл, *наймд*, япон хүмүүсийн ажилч, хичээнгүй чанар, *эцэст нь*, аюулгүй байдлаа АНУ-тай байгуулсан холбоотны гэрээнд даатгаж, батлан хамгаалах зардлыг ДНБ-ний 1 хувиас хэтрүүлэхгүй байх Үндсэн хуулийн заалтаар хязгаарлаж, тухайн салбарт хөрөнгө мөнгийг

үлэмж хэмжээгээр хэмнэсэн эдгээр байв.¹⁴

Зорилтууд, зорилго, стратеги, арга хэмжээ хэмээх OGSM загвар нь стратеги төлөвлөлтөд хэрэглэгддэг зорилго тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээ юм. Үүнийг байгууллага, хэлтэс, баг, заримдаа хөтөлбөрийн менежерүүд зорилгодоо хүрэх хэмжигдэхүйц зорилго, үйл ажиллагааг тодорхойлох, хянахад ашигладаг. Зорилго, стратеги, үйлдлээ бүгдийг нэг хуудсан дээр баримтжуулах нь бусад хүрээнүүдэд дутуу байж болох ойлголтуудыг өгдөг. Энэ нь зорилгодоо хүрэхийн тулд дагаж мөрдөх арга хэмжээг тодорхойлж, бүлгүүдэд чиг үүрэг, газарзүйн зай, байгууллагын хэмжээнд нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад тусалдаг. OGSM-ийн гарал үүсэл нь дэлхийн II дайны дараа 1950-иад оны дунд үед Худалдаа, аж үйлдвэрийн яамнаас чиглүүлж, Японы компаниудын боловсруулж, авч хэрэгжүүлсэн удирдлагын төлөвлөлтийн загвар түүнээс хойш *Fortune* 500-д багтсан олон компани үүнийг авч ашигласан. Ялангуяа Procter & Gamble дэлхий даяарх үндэстэн дамнасан корпорацынхаа менежментийг үүний дагуу хэрэгжүүлжээ.¹⁵

OGSM модель нь стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үндэс суурийг бүрдүүлдэг бөгөөд төлөвлөгөөг өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болгон хадгалдаг удирдлагын хүчтэй горимыг бүрдүүлдэг. Энэ нь удирдагчдыг компанийн зорилгод нийцүүлж, гол стратегиудыг санхүүгийн зорилтуудтай холбож, компанийн чадавхыг сайжруулах ажилд харагдахуйц, хариуцлагатай байдлыг бий болгодог. OGSM нь стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, зах зээлийн боломжийг олж авах, нөөцийг оновчлох, хурд болон гүйцэтгэлийг сайжруулах, багийн гишүүдийг

Диаграм 2. OGSM модель




¹⁴ The Constitution of Japan. https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html

¹⁵ “Standard Model Marketing Strategy (OGSM)”. Archived from the original on 18 May 2015. Pepper, John (1 May 2007). *What Really Matters: Service, Leadership, People and Values*. Yale University Press. pp. 147–148. ISBN 978-0-300-12352-4. Retrieved 28 May 2015. OGSM.

нэгтгэх зорилготой юм.¹⁶

PDCA (Plan-төлөвлөх- Do-гүйцэтгэх-Check-үнэлгээ хийж сайжруулах- Act-үйл ажиллагаа, тохируулах) бизнесийн үйл явц, бүтээгдэхүүнийг хянах, тасралтгүй сайжруулахад чиглэгдсэн мөчлөг, удирдлагын хяналтын аргачлал юм.¹⁷ Үүнийг Shewhart цикл буюу хяналтын тойрог/мөчлөг гэж бас нэрлэдэг. Нэмэгдсэн “О” нь ажиглалтыг илэрхийлдэг эсвэл зарим хувилбарт “Одоогийн нөхцөл байдлыг ажигла” гэж хэлдэг. Ажиглалт, өнөөгийн нөхцөл байдалд онцлон анхаарч байгаа нь хэмнэлттэй үйлдвэрлэл, Тоёотагийн үйлдвэрлэлийн системдээ PDCA мөчлөгийг хэрэгжүүлсэн.¹⁸ Ишикавагийн өөрчлөлт бүхий PDCA мөчлөгийг 1959 онд Токиогийн Технологийн Хүрээлэнгийн С.Мизүногийн үеэс харж болно.[4]

Диаграм 3. PDCA мөчлөг



Японы нийгмийг үндэсний соёл уламжлал, модернизацийн цогц хослол гэж үздэг. Япончууд өнгөрсөн түүхээсээ гүн гүнзгий сургамж авч, өнгөрсөн түүхэндээ гүн гүнзгий дүн шинжилгээ, дүгнэлт хийсэн ажгуу.

Японы томоохон эдийн засагч Канаме Акамацугийн тэмдэглэснээр 1960-1970-аад онд Японы хөгжлийн стратеги нь **“хөөж гүйцэх”**, 1980-аад он гэхэд **“гүйцэж түрүүлэх”** эдийн засгийн философи байсан бөгөөд энэ нь ч ёсоор болжээ.¹⁹ Энэ стратеги ч Зүүн Азийн шинээр аж үйлдвэржсэн бар орнууд болох Өмнөд Солонгос, Сингапур, Тайвань, Хонг-конгийн хөгжлийн баримтлал болсон юм.²⁰

¹⁶ “Wielded Properly, ArchPoint's OGSM Process aligns every element of your business—and improves execution”.

¹⁷ Tague, Nancy R. (2005) [1995]. “Plan–Do–Study–Act Cycle”. The quality toolbox (2nd ed.). Milwaukee: ASQ Quality Press. pp. 390–392. ISBN 978-0873896399. OCLC 57251077.

¹⁸ Rother, Mike (2010). *Toyota kata: managing people for improvement, adaptiveness, and superior results*. New York: McGraw-Hill. ISBN 978-0071635233. OCLC 318409119.

¹⁹ Tausch, Arno. *Kaname Akamatsu: Biography and Long Cycles Theory*. https://www.sociostudies.org/almanac/articles/kaname_akamatsu_biography_and_long_cycles_theory/

²⁰ Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. ХХ зууны сүүлийн хагаст. Дэд боть. УБ., 2020, 228-244 дэх тал

Зураг 2. Канаме Акамацугийн галуу цувааны парадигм



Үйлдвэржүүлэлтийн стратеги нь 1950-60-аад онд импорт орлосон, нефть-хими, хар болон өнгөт металлургийн үйлдвэр, 1960-70-аад оны эхнээс экспортод чиглэсэн электроникийн үйлдвэрлэлийг хөгжүүлж иржээ.

1970-1980-аад оны заагт Япон нь автомашин, хөлөг онгоц, хар болон өнгөт металлургийн үйлдвэрлэлээр АНУ-тай эн зэрэгцэж, гэр ахуйн өргөн хэрэглээний цахим бүтээгдэхүүн, программын удирдлагатай суурь машин, үйлдвэрийн роботоор дэлхийд тэргүүн байранд гарч иржээ.²¹ 1980-аад оны эхнээс эрдэм ухаан шингэсэн электроникийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дэлхийн зах зээл дээр цор ганц өрсөлдөгч болсон байна.

1980-аад оноос үйлдвэрлэлийн хоёр дахь шатны бүтцийн өөрчлөлтийг эхлүүлж, үйлдвэрлэлийн процессыг иж бүрэн автоматжуулах, роботжуулах, хэрэглээний компьютер, мэдээлэл-тооцоолон бодох машин, хагас дамжуулагч, оптик, сансрын технологийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлж, хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах, ХАА-д биотехнологи нэвтрүүлж эхэлжээ. Хатуу хучилттай дээд зэрэглэлийн хурдны болон өндөр хурдны гал тэрэгний хийгээд метроны зам 1.2 сая км-т хүрсэн нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт болж, хот, хөдөөгийн мэдэгдэхүйц ялгааг бүхэлд нь арилгасан байна. R&D-д оруулсан 130 тэрбум ам.долларын санхүүжилтээр 700 мянган эрдэмтэн судлаачид шинжлэх ухаан-техник, технологийн хамгийн тэргүүлэх салбарт ажиллах болсон нь дэлхийд хоёрдугаар байранд орох үзүүлэлт болов.

Физик, хими, анагаах ухааны суурь судалгааны салбарт Японы 20 гаруй эрдэмтэн профессорууд Нобелийн шагнал хүртсэн нь тус улсын шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн чадавх, хүрсэн түвшнийг

²¹ Japan becomes an Economic Powerhouse in the 1970s and 1980s
<https://factsanddetails.com/japan/cat24/sub155/item903.html>

эрхгүй харуулж байв. 2011 оны 3 дугаар сард Фукушима Дайчи атомын цахилгаан станцад гарсан осол бол технологийн хоцрогдол, буруу шийдэл, хариуцлагагүй үйлдлийн алдаа биш, харин байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан гэдэг нь тодорхой болсон билээ.

Японы эдийн засагт "Matsushita", "Fujitsu", "Mitsui", "Sumitomo", "Itochu", "Daichi", "Nikondenkai", "Marubeni" "Kenwood" зэрэг санхүү-аж үйлдвэрийн conglomerate группүүд чухал үүрэгтэй бөгөөд "Toyota", "Subaru", "Nissan", "Honda", "Suzuki", "Mazda", "Mitsubishi", "Isuzu" зэрэг автомашины, "Sony", "Toshiba", "Hitachi", "Sharp", "Panasonic", "Fuji", "Sanyo", "Yamaha" "JVC" "Canon Inc.," зэрэг электроникийн компаниуд өөрийн брэнд бүтээгдэхүүнээрээ бүр 1970-аад оны эхнээс л дэлхийд нэрд гарсан юм.

"2010 онд" ДНБ-ний хэмжээгээр 15.06 их наяд ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг АНУ-ын дараа 5.8 их наядаар тооцогдох бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн хоёрдогч том эдийн засаг, 1.1 их наяд ам.долларын валютын нөөц бүхий Япон улс 6.9 их наядын үйлдвэрлэл явуулж, 3 их наядын гадаад валют нөөцөлсөн, массын эдийн засаг, хүн амтай Хятадад байраа тавьж өгсөн ч²² XXI зуунд технологийн хөгжлийн гайхамшгийг цаашид ч үргэлжлүүлэн харуулах чадавхтай орон юм.

Хөгжиж байгаа орнуудад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд 9.7 тэрбум ам.долларыг буцалтгүй тусламжид зарцуулж байгаа нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт болно.²³

Японы гадаадад хийсэн шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2011-2019 онд нийт 232.8 тэрбум, 2020 онд 115.7 тэрбум ам.долларт хүрч, түүний хуваарилалт голлон АНУ, Зүүн Ази, Өрнөд Европт ногджээ.²⁴ Экспортын гол түншид Хятад 18.8 хувь, АНУ 16.4 хувь, Өмнөд Солонгос 8.1 хувь, Тайвань 6.2 хувь, Хонгконг 5.4 хувь үлдсэн нь ЕХ-ны орнууд, импортын хувьд Хятад 22.2 хувь, АНУ 10.9 хувь, Австрали 6.9 хувь, Саудын Араб 5.2 хувь, Арабын Нэгдсэн Эмират 4.1 хувь, Өмнөд Солонгос 4 хувь, Индонез 3.9 хувийг эзэлж, сүүлийн 30 гаруй жил гадаад худалдаанаас тасралтгүйгээр жилд дунджаар 100 тэрбум ам.долларын ашиг олжээ.²⁵

Япон нь дижитал эдийн засаг²⁶, зөөлөн хүчний чансаагаар дэлхийд эхний 10 дотор эрэмбэлэгдэж байгаа юм.²⁷

²² China Overtakes Japan as World's No. 2 Economy By Andrew Monahan Feb. 14, 2011 <https://www.wsj.com/articles/SB>

²³ Hiroyuki Hoshiro. Japan's Foreign Aid Policy: Has It Changed? Thirty Years of ODA Charters. *Social Science Japan Journal*, Volume 25, Issue 2, Summer 2022, pp. 297–330, <https://doi.org/10.1093/ssjj/jyac010>

²⁴ Foreign direct investment, net inflows (% of GDP) – Japan. <https://data.worldbank.org/indicator/BX.KLT.DINV.WD.GD.ZS?locations=JP>

²⁵ ". www.jetro.go.jp. Retrieved 2018-07-13.

²⁶ Country-level digital competitiveness rankings worldwide as of 2021 <https://www.statista.com/statistics/1042743/worldwide-digital-competitiveness-rankings-by-country/>

²⁷ Global Soft Power Index 2022: USA bounces back better to top of nation brand ranking. 15 March 2022

Япон нь түүхий эдийн нөөцгүй боловч, хамгийн их цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч, мөн хамгийн том хэрэглэгч орон юм.²⁸

Японы дэлхийн эдийн засагт үзүүлж буй жин, нөлөө нь дурдсан улсыг НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүний суудалд нэрийг нь дэвшүүлэхэд хүргэж байгаа бөгөөд Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн АНУ, Их Британи, Франц бүрэн дэмжиж, ОХУ, БНХАУ ямар нэг байдлаар дэмжихээ илэрхийлдэг. Япон нь Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүнээр нэг бус удаа сонгогдож, дэлхийн нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулсаар ирэв. Нөгөө талаар Япон нь НҮБ-ын мөнгөн санд “хамгийн том хандивлагч” орон бөгөөд нийт санхүүжилтын 19.5 хувь буюу 280 сая ам.доллар төлдөг, үүгээрээ АНУ-ын дараа хоёрт ордог ажээ.²⁹

1975 оны 11 дүгээр сард Парисын ойролцоох Рамбуйе шилтгээнд зохиогдсон аж үйлдвэржсэн, ардчилсан орнуудын төр, засгийн тэргүүн нарын анхны дээд түвшний уулзалтаар Их Долоогийн бүлгийн үндсийг тавилцаж, Ерөнхий сайд Масаёши Охирагийн үед 1979 онд Токиод, Ясухиро Накасонэгийн үед 1986 онд Токиод, Кийчи Миязавагийн үед 1993 онд мөн Токиод, Ёширо Моригийн үед 2000 онд Окинавад, Ясуо Фукудагийн үед 2008 онд Хоккайдод, Абэ Шинзогийн үед 2016 онд Ватакано арлын Шима хотод Их Долоо болон Их Наймын дээд түвшний уулзалтыг тус тус амжилттай зохион байгуулж байв.³⁰



*Их 6-гийн анхны дээд түвшний уулзалт.
1975.11.15-16*



Парис, Франц, Рамбуйе шилтгээн

<https://brandfinance.com/press-releases/global-soft-power-index-2022-usa-bounces-back-better-to-top-of-nation-brand-ranking#:~:text=The%20country's%20Global%20Soft%20Power,3rd%20to%202nd.>

²⁸ Electricity market in Japan - statistics & facts. <https://www.statista.com/topics/7479/electricity-market-in-japan/>

²⁹ Anthony McDermott. Japan's financial contribution to the UN system: In pursuit of acceptance and standing pp. 64-88 Published online: 08 Nov 2007, <https://doi.org/10.1080/13533319908413772>
<https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/13533319908413772?journalCode=finp20>

³⁰ Share of global gross domestic product from G7 and G20 countries in 2021 and projections for 2027 <https://www.statista.com/statistics/722962/g20-share-of-global-gdp/#:~:text=In%202021%2C%20the%20G7%20countries,to%20drop%20to%2027.95%20percent.>

2019 оны 6 дугаар сард Японы Осака хотноо Их 20-ийн дээд түвшний уулзалтыг Абэ Шинзогийн Засгийн газар амжилттай зохион байгуулсан юм.³¹



Их 20-ийн дээд түвшний уулзалт. Осака, Япон, 2019.06.28-29

1980-аад оны эхнээс Японы эрх баригчид “Япон бол Өрнөдийн Хамтын нийгэмлэгийн гишүүн мөн”³² буюу Өрнөдийн гүрэн гэсэн номлол дэвшүүлсэн бөгөөд энэ нь эдүгээ хүртэл Японы Засгийн газрын гадаад бодлогын үндэс болсон хэвээр байгаа билээ.

Япон Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны үзэл баримтлалыг 1970-аад оны эхэн үеэс дэвшүүлэн тавих болсон юм. Тийнхүү 1989 оны 11 дүгээр сард Австралийн нийслэл Канберра хотод зохиогдсон анхны Гадаад хэргийн сайд нарын уулзалтаар АПЕК-ын үндэс суурийг тавилцаж, АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтоны санаачилгаар



АПЕК-ийн 18 дахь удаагийн дээд түвшний уулзалт, Ёкохома. Япон, 2010.11.13-14

³¹ Ibid,

³² Japan's part as a “member of the Western community” - *International Relations of Japan* Edited by Kathleen Newland. Springer, Jul 27, 2016 - Political Science - 232 pages

АНУ-ын Вашингтон муж улсын Сиэтл хотын ойролцоо орших Blake Island-д АПЕК-ын гишүүн эдийн засгийн анхны дээд түвшний уулзалт амжилттай зохион байгуулагдсан бөгөөд Япон нь АПЕК-ын дээд түвшний уулзалтыг 1995 оны 11 дүгээр сард Осакад, 2010 оны 11 дүгээр сард Ёкохамад тус тус амжилттай зохион байгуулсан юм.³³

Chase Manhattan Bank (өнөөгийн JP Morgan Chase)-ны Захирлуудын зөвлөлийн тэргүүн тэрбумтан Дэвид Рокфеллерын санаачилгаар Хойд Америк, Өрнөд Европ, Японы хамтын ажиллагааг зохицуулан нягтруулах зайлшгүй шаардлагыг үндэслэн 1973 оны 6 дугаар сард “аж үйлдвэржсэн, ардчилсан” гурван төв Нью-Йорк, Парис, Токиог оролцуулсан “Гурван талын Хамтын нийгэмлэг” хэмээх *think tank*-ийг байгуулсан юм. Байгууллагын зорилго нь “олон улсын харилцааны системийг шинэчлэх”, шаардлага нь “харилцан хамаарал” гэж үзэж байв. “Гурван төвийн Хамтын нийгэмлэг”-ийг “Дэлхийн сүүдрийн Засгийн газар” хэмээн нэрлэх нь буй.³⁴

Диаграм 2. Гурван талт комисс: Нью-Йорк-Токио-Парис



Япон улс 1964 оны Токиогийн зуны XVIII, 2020 оны Токиогийн зуны XXXII, 1972 оны Саппорогийн өвлийн XI, 1998 оны Нагонагийн өвлийн XVIII Олимпын тоглолтыг тус тус нэр хүндтэй зохион байгуулсан билээ.

³³ Asia-Pacific Economic Cooperation (APEC): The First Decade. Werner Draguhn, Eva Manske, Jürgen Rüland Routledge, 2013 - Social Science - 240 pages

³⁴ American Hegemony and the Trilateral Commission. (1992) Cambridge University Press; *Revised edited by Stephen Gill.*

Trilateralism: The Trilateral Commission and Elite Planning for World Management. (1980) Edited by Holly Sklar

III. Японы шинэ капитализм

Алтан үе рүү буцах нь: Кишидагийн шинэ капитализм цалингийн өсөлт, татварын бодлогод ихээхэн анхаарал хандуулдаг тул уламжлалт дахин хуваарилах эдийн засагтай төстэй юм. Өөрөөр хэлбэл, шинэ капитализм нь бүхэлдээ шинэ зүйл биш бөгөөд 1960-аад оны үед бүтээлч байдал гараас гарт дамжин өсөж байсан хуучин "капитализмын алтан үе"-ийг эргэн сэргээх аж. Тухайн үед төрийн эрх барьж байсан Либерал ардчилсан нам орлогыг дахин өсгөх бодлогыг амжилттай хэрэгжүүлсний ачаар ДНБ-ийн дундаж өсөлт хоёр тоонд байсны дээр ажилчдын цалин 1960-1967 оны хооронд хоёр дахин нэмэгджээ. Кишида энэхүү давхар өсөлтийг дахин авчрахыг хүсэж³⁵, үүнийгээ өсөлт, хуваарилалтын амжилттай тойрог гэж нэрлэж байна.³⁶

IV. Монгол Улс, Япон Улсын энх тайван хөгжилт цэцэглэлтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэл, түүний онцлог

Аж үйлдвэржсэн, ардчилсан Япон гүрэн бол Монгол Улсын зах зээлийн харилцаа, ардчилсан тогтолцоонд шилжих үйл явцыг анхнаас нь тууштай дэмжиж ирсэн бөгөөд Монгол Улсын "гуравдагч хөрш", стратегийн түнш, хамгийн том хандивлагч юм.

Монголын төр засаг 2021 оны хавар "Япон лугаа адил хөгжье" гэсэн уриалга дэвшүүлсэн нь даган дуурайх, шууд хуулбарлах тухай биш гэдэг нь нэн тодорхой бөгөөд харин дэлхийн дайнд ялагдсан, байгалийн баялаг байхгүй сайх улс экспортын бүтэцтэй аж үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрхэн амжилттай хэрэгжүүлсэн, иргэд нь хэрхэн ажилч хичээнгүй, өндөр ёс суртахуунтай, шинийг санаачлагч гэдгээс л суралцах тухай асуудал ажгуу.

2022 оны 11 дүгээр сарын сүүлээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хоёр улсын Хамтарсан Мэдэгдэлд: "Өнөө цагт эрх чөлөө, ардчилал, хүний эрх, хуулийн засаглал зэрэг нийтлэг үнэт зүйлс бүхий "Стратегийн түнш" болсныг дахин нотолж...талууд бүс нутаг, олон улсын нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөж байгаа үед хуулийн засаглалд суурилсан чөлөөт, нээлттэй олон улсын дэг журмыг хадгалж, бэхжүүлэх, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг бий болгох, энх тайван, тогтвортой байдлыг хангах асуудал урьд өмнө байгаагүйгээр чухлаар тавигдаж

³⁵ Эдийн засаг нь асар хурдацтай дижиталчлагдаж байна. Батлан хамгаалах зардал ирэх 5 жилд 350 тэрбум буюу 48 их наяд иен зарцуулахаар төлөвлөв.

³⁶ Can Japan's 'New Capitalism' Help Its Workers? By Ulv Hanssen. February 16, 2022 <https://thediplomat.com/2022/02/can-japans-new-capitalism-help-its-workers/>

буйг дахин нотлов. Мөн энэ хүрээнд аливаа бүс нутагт нөхцөл байдлыг хүчээр, нэг талын шийдвэрээр өөрчлөх асуудлыг үл хүлээн зөвшөөрч, олон улсын хууль, журамд үндэслэн мөргөлдөөнийг энх тайвны аргаар шийдвэрлэхийн чухлыг дахин нотлов. Эдгээр нөхцөл байдлын улмаас бүс нутаг, олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайван, хөгжил цэцэглэлтийг бий болгохын төлөө цаашид хамтран ажиллаж, хувь нэмэр оруулах зорилгоор хоёр улсын харилцааг шинэ түвшинд хүргэж, “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийг байгуулахаар санал нэгдэв”³⁷ гэсэн байна.

Монгол Улсын хоёр хөрштэй байгуулсан “Иж бүрэн бүрэн стратегийн түншлэл”-ээс ялгагдах онцлог нь “үнэт зүйл”, түүнчлэн “олон улсын хууль, дүрмийг дээдлэх” гэдгийг тодотгох нь зүйтэй юм.

“Түнш”, “түншлэл” хэмээх нэр томъёо нь 1990-ээд оны эхнээс олон улсын харилцааны үг хэллэгт бодлогын шинжтэй, шинэ агуулга, хэлбэртэйгээр баттай орж ирсэн байдаг. Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй, харин улс орнуудын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгож, харилцан хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж хамтын ажиллагаандаа баримтлах зарчмаа төлөв тодорхойлж байна. Тэгэхлээр түншлэл нь “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд “иж бүрэн” байж болно, “стратегийн” байж болно, “олон талтай”, эсвэл “өргөн хүрээтэй” байж болно, мөн “оюун санааны” түншлэл байж болно. “Стратегийн түншлэл”-д улс төр, эдийн засаг, аюулгүй байдал зэрэг өргөн хүрээтэй асуудал тусгагддагаас гадна гол нь энэ харилцаа урт хугацаанд, тогтвортой үргэлжилнэ гэсэн гол баримтлал хамт явж байдаг. Энд “эвсэл холбоотны” эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, “ах дүүгийн” харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулга тусгагддаггүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм. Стратегийн түншлэлийн дунд, урт хугацааны хөтөлбөр бол хамтын ажиллагааг хэрэгжүүлэх Замын зураглал юм.

³⁷ “Монгол Улс, Япон улсын хооронд энх тайван, хөгжил, цэцэгжилтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэл” 2022.11.29 Токио, Япон